



IV-VI/2022

Тархаасан: 2022 оны 7 дугаар сарын 18




## Монгол Улсаас 115 иргэн БНСУ-д, 52 иргэн Япон Улсад хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар 2022 оны 2 дугаар улиралд зуучлагдсан байна

Хөдөлмөрийн гэрээгээр цалин хөлстэй ажил эрхлэхээр зуучлагдсан иргэдийн тоо 2022 оны 2 дугаар улиралд 167 болж, өмнөх улирлаас 236 (58.6%) хүнээр буурсан байна. Хөдөлмөрийн гэрээгээр цалин хөлстэй ажил эрхлэхээр зуучлагдсан иргэдийн 117 (70.1%) нь эрэгтэй, 50 (29.9%) нь эмэгтэй байна.

Хөдөлмөрийн гэрээгээр цалин хөлстэй ажил эрхлэхээр зуучлагдсан иргэдийн хамгийн их буюу 37.7 хувь нь 30-34 насныхан, 24.0 хувь нь 35-39 насныхан байгаа бол хамгийн бага буюу 2.4 хувь нь 45-54 насныхан байна.

ЗУРАГ 1. ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭГЭЭР ГАДААД УЛСАД ЗУУЧЛАГДСАН ИРГЭД, 2022 оны 2 дугаар улирлын байдлаар, насны бүлгээр, хүйсээр, дүнд эзлэх хувиар



Хөдөлмөрийн гэрээгээр цалин хөлстэй ажил эрхлэхээр зуучлагдсан иргэдийн 89 (53.3%) нь бакалаврын дээд, 55 (32.9%) нь бүрэн дунд, 19 (11.4%) нь техникийн болон мэргэжлийн, 3 (1.8%) нь магистр, доктор, 1 (0.6%) нь суурь боловсролтой байна.

Хөдөлмөрийн гэрээгээр зуучлагдсан иргэдийн 115 (68.9%) нь боловсруулах үйлдвэрлэлийн салбарт, 32 (19.2%) нь хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагааны салбарт, 15 (9.0%) нь хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын салбарт, 5 (3.0%) нь барилгын салбарт ажил эрхлэхээр зуучлагджээ.

### Ойлголт, тодорхойлолт:

Хөдөлмөрийн гэрээгээр гадаад улсад зуучлагдсан иргэн нь цалин хөлстэй хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар зуучлагдсан хүмүүс юм.



**Эх үүсвэр:**

Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яам

**Мэдээлэл авах холбоос:**

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

**Дараагийн мэдээ тархаах хуваарь:**

2022 оны 10 дугаар сарын 14

Нийгмийн статистикийн газрын  
даргын үүргийг түр орлон  
гүйцэтгэгч Э.Эрдэнэсан  
Утас : (976-51)-266414

Нийгмийн статистикийн газрын Өрхөд  
суурилсан судалгааны хэлтсийн  
статистикч Л.Даваажаргал  
Утас : (976-51)-265543

